



УЛААНБААТАР
ХОТЫН АРДЫН ДЕПУТАТУУДЫН ХУРЛЫН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРГААНЫ

ТОГТООЛ

1995 оны 12 сарын 12 өдөр

Дугаар 226

Улаанбаатар хот

ДҮРЭМ БАТЛАХ ТУХАЙ.

Хотын Тэвэг 1990 оон 228-р тусламжур хуралын

Улаанбаатар хотын АДХ-ын гүйцэтгэх захиргаанаас

ТЭГТООХ НЬ:

1. БИМАУ-ын Сагд нарын Зөвлөлийн 1984 оны 377 дугаар тогтоолоор Хотын Архитектур төм. влөлтийн газрын дэргэд шинэ албад байгуулагдаж орон тоо зохион байгуулалтанд нь оорчлолт орсонтой холбоотуудан, тус газрын дүрмийг өмчлөн баталсугай.



УЛААНБААТАР ХОТЫН АДХ-ЫН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРГААНЫ

ДАРГА *[Signature]* С.МӨНХЖАРГАЛ.

ХАРИУЦАГАТАЙ НАРИЙН БИШГҮЙН

ДАРГА *[Signature]* Ч.ЖАМБАЛ.

Улаанбаатар хотын АДХ-ын Гүйцэтгэх захиргааны 1985 оны 12 р сарын 12 ний өдрийн 26 р тогтоолоор батлав.

УЛААНБААТАР ХОТЫН АРХИТЕКТУР ТӨЛӨВЛӨЛТИЙН ГАЗРЫН ДҮРЭМ

Нэг. Нийтлэг үндэслэл.

1. Архитектур төлөвлөлтийн газар нь хотын ерөнхий төлөвлөгөөг хэрэгжүүлж, хот байгуулалтын шинжлэх ухааны үндэслэлтэй бодлогыг явуулан нийслэлийн барилгажилтын архитектур төлөвлөлтийн чанарыг өндөр түвшинд байлгах ажлыг хариуцсан байгууллага мөн. Үүнээс гадна хотын гудамж зам талбайн тохижилт, гэрэлтүүлэг, гэрлэн чимэгмэл, шинээр баригдах барилгын болон хотын АДХ-ын гүйцэтгэх захиргааны шууд харьяа байгууллагуудын захиалгатай засварын зураг, төсөв зохиох ажлыг эрхлэнэ.

2. Архитектур төлөвлөлтийн газрын үндсэн зорилт нь хотын шинэ ерөнхий төлөвлөгөө, дагуул хот, орон сууц, үйлдвэр аж ахуй, агуулахны районы ерөнхий төлөвлөгөөний хэрэгжилтийг хангуулж эдэлбэр газрын ашиглалт, түүх, соёлын дурсгалт зүйл, ус хөрс агаарын бассейн ногоон бүсийн хамгаалалтыг сайжруулж, нийслэл ба түүний дүүргийн барилгажилтын төлөвлөлт ур хийц, өнгө үзэмж, барилга угсралтын чанарыг өндөр түвшинд байлгахад оршино.

3. Хотын Архитектур төлөвлөлтийн газар нь Улаанбаатар хотын АДХ-ын гүйцэтгэх захиргаанд шууд захирагдана.

4. Хотын Архитектур төлөвлөлт, барилгажилтын ажилтай холбогдсон чухал асуудлыг хэлэлцэж шийдвэрлэх үүрэгтэй "Хот байгуулалтын зөвлөл", "Тазар олголтын комисс", архитектур төлөвлөлтийн газрын дэргэд ажиллах бөгөөд зөвлөлийн гишүүдийн бүрэлдэхүүнийг хотын АДХ-ын гүйцэтгэх захиргаа батлана.

5. Архитектур төлөвлөлтийн газрын зохион байгуулалтын бүрэлдэхүүнд зураг төсвийн товчоо, хот байгуулалт-төлөвлөлтийн хэлтэс, архитектурын хяналтын алба, цехурын ерөнхий төлөвлөгөөний алба гэсэн нэгжүүд багтана.

6. Хотын Архитектур төлөвлөлтийн газар нь үйл ажиллагаандаа холбогдох хууль тогтоомж, акт, эмэ дүрмийг удирдлага болгоно.

7. Хотын Архитектур төлөвлөлтийн газар нь хуулийн этгээд мөн бөгөөд зохих журмаар хийсэн тэдгээг, хэвлэмэл хуудас хэрэглэнэ.

8. Хотын Архитектур төлөвлөлтийн газар нь оөрийн үйл ажиллагааныхаа тайланг гаргаж жил бүрийн нэгдүгээр сард багтаан хотын АДХ-ын гүйцэтгэх захиргаанд оруулж хэлэлцүүлнэ.

Хоёр. Хотын Архитектур төлөвлөлтийн газрын үүрэг.

1. Хотыг барилгажилтын ерөнхий төлөвлөгөө, нарийвчилсан ерөнхий төлөвлөгөөний дагуу барьж байгуулах ажлыг удирдан зохион байгуулана.

2. Хотын ерөнхий төлөвлөгөө, орон сууц, үйлдвэр, аж ахуй, агуулахын, район, дагуул хотуудын нарийвчилсан ерөнхий төлөвлөгөө, ийм нөрийн хангамжийн ерөнхий схемийг зохиолгоно.

3. Хотын инженерийн хангамжийн барилгажилтын хэтийн төлөвтэй нягт уялцуулан төлөвлөж техникийн нөхцлийг хянаж батлана.

4. Хот түүний дүүрэгт баригдах орон сууц, соёл ахуйн болон үйлдвэрийн барилга, бүх төрлийн инженерийн шугам сүлжээ, зам тээврийн байгууламж, хороолол, гудамж зам талбайн тохижилт цэдэрлэгжүүлэлтийн ажлын чанар зураг төслийн хэрэгжилтийн байдалд улсын хяналт тавина.

5. Улаанбаатар түүний дагуул хотуудын нутаг дэвсгэр дээр шинээр баригдах барилга байгууламжийн байршилтыг тогтоож, газар олгох асуудлыг боловсруулж хотын АДХ-ын гүйцэтгэх захиргаанд оруулж шийдвэрлүүлнэ.

6. Хотын эдэлбэр газрын ашиглалт, хот байгуулалтын дэг журмын хэрэгжилтийн байдалд хяналт тавина.

7. Улаанбаатар түүний дагуул хотуудын нутаг дэвсгэр дээр хийгдэх газрын зурагмал, инженерийн хайгуулын ажлыг төлөвлөн зохицуулж, хайгуулын материалыг системчилэн нэгтгэж төвлөрүүлнэ.

8. Хотын барилгажилт, инженерийн шугам сүлжээний жижүүрийн зургийг хотлоно.

9. Хотын хороолол, гудамж зам талбайн тохижилт, гэрэлтүүлэг, гэрлэн чимэглэл, архитектурын жижиг биетүүдийн болон хотын харьяа зарим байгууллагуудын засварын зураг, төсөв мөн улсын хөрөнгө оруулалтаар баригдах шинэ барилга байгууламжийн зураг төслийг зохионо.

10. Ашиглагдаж байгаа барилга байгууламжийн давхаржилт өрөө тасалгаа зориулалтыг өөрчлөх, хаалга цонх шинээр гаргах, битүүлэх, барилгын гадна өнгийг засч будах зөвшөөрөл олгоно.

Гурав. Хотын Архитектур төлөвлөлтийн газрын эрх.

1. Ерөнхий төлөвлөгөөнд баригдахаар тусгагдаагүй барилга байгууламжинд газар олгохоос татгалзах.

2. Газрыг зөвшөөрөлгүй эзэмших, хотын нутаг дэвсгэр дээр ямарваа төрлийн барилга байгууламжийн дур мэдэн барих зэргээр БНМАУ-ын газар эдэлбэрийн хууль, хотын барилгажилтын дүрмийг зөрчсөн буруутай этгээцэд зохих журмын дагуу торгууль ноогдуулах зэрэг захиргааны арга хэмжээ авахуулах.

3. Шинээр барих болон өргөтгөх барилгын зураг төслийн шийдэл нь архитектур төлөвлөлтийн шаруулагад нийцэхгүй байвал дахин хайлгах.

4. Архитектур төлөвлөлтийн дээдгараар болон зураг төслийг хянах явцад тавигдсан тодорхой шаардлагуудыг хангаагүй нөхцөлд тухайн барилгад олгогдсон газраг хүчингүй болгох санхүүг хотын АДХ-н гүйцэтгэх захиргаанд оруулах.

5. Захмалагч болон холбогдох бусад байгууллагуудас барилга байгууламжийн байршилтыг тогтооход шаардлагатай үндсэн материалуудаас гадна нэмэлт судалгаа тооцоо хүлээнгэлийг гаргуулан авах.

6. Барилга байгууламж барих үед гарсан зөрчил гологдлыг арилгах хүртэл уг ажлаа цаашид үргэлжлүүлэхийг зогсоож дугуу буюу буруу хийсэн ажлаа гүйцээж хийтэл тухайн ажлын санхүүжилтийг хаах

7. Хотын дэвсгэрийн бүх албан үйлдвэрийн газар, барилдаж байгаа барилгуудад чөлөөтэй нэвтрэн орж эдэлбэр газрын амьдралт, барилгын чанарт амьдралт хийх.

8. Хотын цугтар дэвсгэр дээр зөв барилгүй хийгцэж байгаа зураглал хайгуулын амгуудыг зогсоох.

АРХИТЕКТУР ТӨЛӨВЛӨЛТИЙН ГАЗАР.